



**МОНГОЛ УЛСЫН  
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ  
УЛСЫН КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 0116

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрмийн 2 дугаар зүйлийн 10а, Улсын комиссын Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршиг, үр дагаврыг арилгах, соён гэгээрүүлэх нөлөөллийн чиглэлээр хэрэгжүүлж буй ажлын сайн туршлага солилцох, хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор БНСУ-д ажиллах Улсын комиссын даргаар ахлуулсан айлчлалын хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд Гванжу хотод байрлалтай тус улсын Соёл, Спорт, Аялал Жуулчлалын яамны харьяа Азийн соёлын төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, Азийн хэлмэгдүүлэлтэд өртсөн улс орны сүлжээ байгууллагад гишүүнээр элсэх, мөн Говийн ноён хутагтын музейн үзмэрээр баяжуулсан “Монголын нэн шинэ үеийн түүх: Их хэлмэгдүүлэлт ба Соёлын устгал” нэртэй тусгай үзэсгэлэн гаргах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлах:	Э.Ариунбат	Улсын комиссын салбар комисс, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Л.Очирсүрэн	Улсын комиссын Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга
	Б.Батжаргал	Улсын комиссын зөвлөх, гэрээт орчуулагч
	Ли Хэра	Азийн соёлын төвийн Олон нийтийн харилцаа, хамтын ажиллагааны газрын захирлын туслах /тохиролцсоноор/
	А.Алтан-Очир	Говийн ноён хутагтын музейн захирал /тохиролцсоноор/
	С.Мишээл	Юнеско-ийн Монголын Үндэсний комиссын Мэдээлэл, харилцаа холбооны асуудал хариуцсан мэргэжилтэн /тохиролцсоноор/.

2. 2023 оны 11 дүгээр сард БНСУ-д ажиллах албан ёсны айлчлалын бэлтгэл ажлыг хангах, төлөвлөгөө, хөтөлбөр, айлчлалын бүрэлдэхүүн, шаардагдах зардлын төсвийг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тухай бүр танилцуулж ажиллахыг Захиргаа, дүн шинжилгээний албаны дарга Л.Очирсүрэн, Ажлын хэсгийн ахлагч (Э.Ариунбат) нарт үүрэг болгосугай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Г.ТӨГӨЛДӨР